

БАТЛАВ
СУРГАЛТЫН МЕНЕЖЕР **ГАНХЖАРГАЛ**

11-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТ

ХУВИЛБАР-А

Хугацаа: 60 минут

Нийт 40 оноо

Төрийн тулх

Дамдингийн Дэмбэрэл. Энэ нэрэнд итгэл найдвар, тулх харагдана. Монголын улс төрийн дэлгэц дээр ийм агуулгаар нэгэнт дархлаажжээ. Эл дархлаа он цагийн шалгуур, ард түмний итгэл үнэмшлээр баталгаажсан юм. Таван парламентад сонгогдсон нь үндэслэлийн эх. Иим өндөр хувьтай хүн Монголд хоёр л байна. Нэг нь Д.Дэмбэрэл, нөгөө нь Д.Лүндээжанцан. Д.Дэмбэрэл дарга аядуу намуун хүн. Хүлээцтэй. Цочмог хурц араншин огт үгүй. Гэхдээ энэ намуун хүлээцтэй байдлын цаана нь үлэмжийн өндөр зангараг, зүй зохист хүчтэй итгэл үнэмшил нь ёс зүй юм. Ямартаа ч парламентын дөмөг нэгэн сэтгүүлч Д. Дэмбэрэлийн өнгөн дээр парламентийн гишүүний ёс зүйн дүрмийг баталлаа гэж хөхүүнээр бичих вэ дээ. Түүнээс өдгөөгийн улс төрчдийнхөөс ангид олон сайхан чанарыг харж болдог. Тэр том хөөрөг барьж, халиу нударгатай дээл өмсдөггүй. Морь уяж наймаа панз үсэргэхгүй. Чононд явж, хор найруулахгүй. Буй төрхөөрөө л төрийн хар хүн нь мэдэгдээд байдаг. Чигч шударга нь ив илхэн байдаг.

Д.Дэмбэрэл нэр цэвэр. Түүний алив бусармагт холбогдсон нь үгүй. Тийм "Аварга" ийм хууль бусыг хийжээ, ингэж завшжээ гэх мэдээлэл даанч их байх болж. Нийгэм тэр чигээрээ бараан бүрүйн будангуйгаар мэдээлэлжсэн шиг. Ийм цөвүүн, ороо бусгаа цаг үед төр засгийн ууц нуруу болж, ачаа үүрч яваа спикерийн тулх эх оронд нэн чухал. Үүнийгээ эрхэм дарга гэрэл зул болгон хичээмжилж буй.

Д.Дэмбэрэл Алтайн уулсын дунд мэндэлсэн хүн. Уулсын өндөр оргил, талын намуухны аль алиныг нь тэрбээр сэтгэлийн уgt мэдэх билээ. Тэрбээр улсын хэрэг явдлыг уулсын оргил дээрээс харж, талын намуухан бөгөөд илчлэг уур амьсгалаар алив хэрэгт хандах нь төрөлхийн мэт сэтгэгдлийг төрүүлдэг.

Тэр жирийн ардын хүү. Амьдралын ширхгийг бууцны хөлийн хөх хорголыг имрэх мэтээр мэддэг гэхэд хилсдэхгүй. Төрийн засгийн ажлыг мөн чингэж имэрдэг нь мөн чанарынх нь булагт байна

Д.Дэмбэрэл бусдыг сонсох талаараа нэг өөг туршлагатай. Тэрбээр бага доод, зүдүү чадуу, баян тарган хэн бүхнийг чин сэтгэлээсээ сонсдог. Нэг бус удаа сонгогдсон тойрог, нутагт нь хамт явав. Ингэж явахдаа энэхүү бусдыг сонсох, түүгээр дамжин амьдралын эгэл жирийн болоод элдэв бусыг төрийн жинхэнэ түшээгийн зүрх сэтгэлээр мэдэрдгийг анзаарсан билээ. Парламентийн даргын баг бүрэлдэхүүнд хамт явцгаасан хэн боловч үүнийг нь анзаараад хэлж ярилцаж байх нь нэг бус аа.

Д.Дэмбэрэл дарга магтаалаас илүүтэй зэмлэлийг хүлээж авамтгай хүн шиг санагддаг. Түүний парламентийг эх барилцаж, бойжуулалцаж, бүтээж яваа он жилийн түүх үнэнийг өгүүлдэг. Тэрбээр олсон ололтоо хөтөлбөргүй хүдэршүүлж, алдаа мадаг бий аваас гээж засаж ирсэн нь нэр цэврийнх нь магтаалаас илүү зэмлэлийн ая тусыг ухамсарласных нь тусгал болов уу? Төрийн өндөр дээд албан тушаалд туршлага, нэр хүнд, мэдпэг боловсрол, хүн чанар, сэтгэл зүрх бүхнээрээ дэнслэгдээд хүлээн зөвшөөрөгдсөн Дамдингийн Дэмбэрэл бол монгол төрийн тулх юм.

Б.Золбаяр.

Ажиллах даалгавар:

1. Эхээс зохиогчийн үнэлэлт дүгнэлтийг ийлэрхийлсэн өгүүлбэрийг олж бичээд утгыг тайлбарлан бичнэ үү. \4 оноо\

.....
.....
.....

2. Эхэд байгаа “Ийм цөвүүн, ороо бусгаа цаг үед төр засгийн ууц нуруу болж, ачаа үүрч яваа спикерийн тулх эх оронд нэн чухал. Үүнийгээ эрхэм дарга гэрэл зул болгон хичээмжилж буй.” өгүүлбэрийн дүрслэх ур маягийг олж тайлбарлаарай. \4 оноо \

Хэлц:

.....
.....
.....

Тайлбар:

.....
.....
.....

3. Эхийн “Д.Дэмбэрэл дарга аядуу намуун хүн. Хүлээцтэй. Цочмог хурц араншин огт үгүй. Гэхдээ энэ намуун хүлээцтэй байдлын цаана нь үлэмжийн өндөр зангараг, зүй зохист хүчтэй итгэл үнэмшил нь ёс зүй юм.” гэсэн өгүүлбэрийн тодруулсан үгийг утга ойролцоо үгээр солин найруулаарай. \4 оноо \

.....
.....
.....

4. Харагдана гэдэг үгийг үгийн бүтцээр задлан зөв бичгийн дүрмийг тайлбарлан бичнэ үү. \2 оноо\

.....
.....
.....
.....
.....

5. Олчоорой гэдэг үгийг үгийн бүтцээр задлан зөв бичгийн дүрмийг тайлбарлан бичээрэй.\2 оноо\

.....
.....
.....

6. Цэгийн оронд тохирох үйл үгийг зөв харгалзуула уу?\2 оноо\
Эзэд ноёд энд хоргой тортонд хөлбөрч байсан

Өдгөө энэ бүхэн баларч, нурсан балгасны ормон дээр
Өнчин хөхөө ганцаараа гүүг гүүг донгодно гэсэн

7. Зохиолыг төрөл зүйлтэй нь зөв харгалзуулаарай. \5 оноо\

- | | |
|-------------|------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Хамелеон | a. Юм агуулах, хадгалах нарийн хийцтэй жижиг байшин, |
| 2. Пин | b. исгэлэн жимс, мөн ийм жимсгэнэтэй өргөстэй |
| 3. Хамжаар | c. хүрэм цамц |
| 4. Зээл | |
| 5. Тошлог | d. Африк тивд байдаг ногоовтор өнгөтэй боловч
орчны байдал дагаж өнгө хувирдаг, гүрвэлийн төрлийн |

амьтан

Д. Зохиолд зах зээлийн газар гэдэг утгаар орсон.



8. Бэрх хэцүү оньсогыг таагч, хүчирхэг хаан
Бид бүгдээрээ л түүнийг атаархан харж байсан биш үү?
Амьдралынх нь төгсгөл ирээгүй байгаа хүнийг, тэгэхээр
Аз жаргалтай хэмээн дүгнэж болохгүй нь байна шүү" хэмээн ямар зохиолд
гардаг вэ?\1 оноо\

A. Сүүлчийн хичээл	b. Махабхарата	v. Эцэг Горо	g. Эдип хаан
--------------------	----------------	--------------	-----------------

9. Үндэсний бичгээс кирилл рүү хөрвүүлэн бичээрэй. /3 оноо/

بیستو عقوب مقدمه هم نهان هم سهندیو دل خدابدکو
سبیسین یا مادر ن دنندسر . سایر ن بندندسر ما ..

10.“Гэмшил” сэдвээр хүүрнэсэн эх бичихдээ сэдэв, агуулгын уялдаа холбоог гаргаж, уран дүрслэл, хэл найруулгыг оновчтой хэрэглэн, алдаагүй цэвэр сайхан бичнэ үү. Үгийн тоо 150-180 /10 оноо/



БАТЛАВ
СУРГАЛТЫН МЕНЕЖЕР **ГАНХЖАРГАЛ**

**11-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТ
ХУВИЛБАР-Б**

Хугацаа: 60 минут

Нийт 40 оноо

“Эквадорт хийсэн тэмдэглэл” ээс

... Уулын сүрд дарагдан бидний зүрх түгшлээ. Гурван мянган метр өргөгдсөн их уулын сүрлэг хяр дээгүүр, гүн ангал, хадан хясааны ирмэгээр могой мэт тахиралдсан нарийхан замаар бидний суусан автобус уухилан дээшилсээр байлаа. Зарим газар замын хажуугийн эгц энгэр нурж бөөн чулуу шороо овоологдсон, зарим газар үер бууж замын дундуур сэт цохигдсон байлаа. Тэр бүхнийг тойрох, дээгүүр нь дэнжигнэн тэгнэх, гулсан хий эргэх зэргээр гэтлэн давахын тулд автобус, жолооч хоёр зовон зүдэж, дотор нь суусан бид айн бэмбэгнэн явсаар арай гэж даваан дээр гарав. Эргэн харахад тэртээ дор ширүүн урсгалт гол хадан хясаа, гүнзгий хавцал дундуур гаслах мэт бархиран урсаж, алсад Антисанаа гэдэг сүрлэг цаст уулын орой цайвалзан цухуйж үзэгдлээ.

Эквадорын арван найман мужийн нэг болох Имбабура орохоор бид ийнхүү бэдэрч явна. Даваан дээр гартал алсад бас шовх цэнхэр уулс сүндэрлэн давхарлаж хэрэм мэт хүрээлэн харагдлаа. Бидний өмнүүр хөндөлдөн цэнхэртэх сонин уулсаас янагш цэлгэр ногоон хөндий мэлтийж тэртээ үзүүрт нь тогорууны нүд шиг нуур гялтайж байлаа. Даваан дээр гарч тонгоймогц автобус зогсоход бид ухасхийн үүд зүглэлээ.

Биднийг газардмагц өмнөөс минь сонин хувцастай нэгэн эр угтан ирлээ. Хөхөлбий бор царайтай, намхан нуруутай инка хүн ажээ. Мөрөндөө гитар хөгжим зүүжээ. Өвдөгнөөсөө доош саглагар хүрэн үстэй баавгайн годыг сарвууг нь уруу харуулан унжуулсан нь мөчид харвал хоёр хөл нь баавгайнх шиг юм.

Инка хүмүүс баавгайн хумс бүхий сарвуутай годоор хийсэн утыг өвдөгнөөс доош шилбээ дагуулан унжуулж өмд мэтээр өмсдөг байна. Анх харахад цочмоор сүртэй үзэгдэнэ. Тийнхүү бидэнтэй даваан дээр учирсан инка хүн гитараа хөндлөн барьж зогсоод эртний индейчүүдийн сонин дууг хөгжимдэж эхэллээ.

Бид сониучирхан түүнийг тойрч зогсоод дууг чагнав. Уянгалаг аялгуу байлаа. Гунигтай анигар хүрэн нүдэнд нь уярал тодорч, үрчлээт магнай нь үе үе тэнийж өвдөг рүүгээ унжуулсан баавгайн годны сарвуу нь үл мэдэг чичрэгнэнэ. ... Нэг үе гаслан уйлах шиг, нэг үе хилэгнэн зүхэх шиг, тэгснээ эхэр татан зогьсох адил дуу аялгуу гитарын утаснаас цацагдан түгж их уулын сийрэг агаарт тодхон цууртайтаж байлаа. ... Сүүлчийн бизон эсвэл сүүлчийн оронго үхэж тийнхүү аль нэгэн ховор амьттан байхгүй болсон тухай мэдээг дэлхий дахин эмгэнэн сонссон нь олонтаа. Гэвч индейчүүдийг ийм гунигт тавиланд хүргэхийг хүн төрөлхтөн хэрхэвч зөвшөөрөх ёсгүй.

Индейчүүд ...мөхөж сөнөхийн даваанд хүрсэн үедээ 1823 онд маршал Сүкргийн удирдсан зэвсэгт тэмцлийн ачаар аврагджээ. “Идсэн эрүү хувхайрч, идүүлсэн бут ургана” гэгчээр харийн тонуулчид индейчүүдийг дуусгаж чадсангүй, пүүгээгээ үүрээд далайн чанадыг зүглэх цаг нь иржээ.

... индейчүүд ирээдүйдээ итгэл алдсангүй. “Кунан кайа, Майжан, Пуньяя, инти чинг танга” гэж дуулсаар иржээ. Энэ нь “Өнөө юу, маргааш уу? Өөр нэг өдөр үү? Наран гарах даа л нэг гарна” гэсэн утгатай юмсан жээ. Индейчүүдийн жаргалын нар гарах өдөр ойрхон болжээ.

(1985 Л.Түдэв

Ажиллах даалгавар:

1. Эхээс зохиогчийн сэтгэлийн хөдөлгөөний өнгө аясыг илэрхийлсэн өгүүлбэрийг олж, утга санааг тайлбарлан бичнэ үү. \ 4 оноо\.....
•.....
•.....
.....
2. Зохиолч “нар гарах” гэсэн хэлцийг хүний хүсэж хүлээсэн үйл хэрэг бүтэж, ихэд баярлах үйлтэй адилтгасан утгаар сонгожээ. Энэхүү хэлцийн утга санаанд тохирох хэлц дөрвийг сонгож бичнэ үү. /4 оноо/
•.....
•.....
.....
3. “Даваан дээр гартал алсад бас шовх цэнхэр уулс сүндэрлэн давхарлаж хэрэм мэт хүрээлэн харагдлаа.” Гэсэн өгүүлбэрийн онцолсон бүтээврийг цагийн утга илэрхийлэх бүтээврээр солин найруулж бичээрэй. \4 оноо \.....
.....
.....
4. Харчхаарай гэдэг үгийг үгийн бүтцээр задлан зөв бичгийн дүрмийг тайлбарлан бичээрэй. \2 оноо\.....
.....
.....
5. Бэдлчихээд гэдэг үгийг үгийн бүтцээр задлан зөв бичгийн дүрмийг тайлбарлан бичээрэй. \2 оноо\.....
.....
.....
6. Тодорхойлолтыг гүйцээж бичнэ үү \2 оноо\Хоорондоо шууд холбоо төсөөгүй зүйлсийг гадаад дотоод аль нэг шалтгаант холбоо хамаарлаар нь холбон хамаатуулж, нэгийг нөгөөгөөр орлуулан дүрслэх ур маягийг гэнэ.


7. Зөв харгалзуул. \5 оноо\

- | | |
|---------------|----------------------------------------------------|
| 1. Сартваахь | а. Цахилгаан мэт, түр зуурын |
| 2. Гилбэлгээн | б. нааш |
| 3. Янагш | в. зам заагч, удирдагч, тэргүүн |
| 4. Тойн | г. ламын хүндэтгэлийн нэр , язгууртан гаралтай лам |
| 5. Адиистид | д. Соёрхол, өршөөл, аврал |

8. Үнэнийг өгүүлэгч хөвгүүний угийлдлээс үл хамаарахыг олно уу? \2 оноо\

- А. Хамаг эрдмийг гайхамшигтай сурав.
 - Б. Дотоод яамыг мэдэгч ноён болов.
 - В. Эзэн хааны хотод одсоны хойно
Яван ядах эхийг минь хэн тэтгэх
 - Г. Ээж, эхнэр 2 дагуулан явав.

9. Үндэсний бичгээс кирилл руу хөрвүүлэн бичээрэй. /5 оноо/



10.“Хамгийн нандин дурсамж” сэдвээр хүүрнэсэн эх бичихдээ сэдэв, агуулгын уялдаа холбоог гаргаж, уран дүрслэл, хэл найруулгыг оновчтой хэрэглэн, алдаагүй цэвэр сайхан бичнэ үү.
Үгийн тоо 150-180 /10 оноо/

